



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2026/042/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас:70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер:М.Нарантуяа Утас:99029193 Цахим хаяг:Narantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: Ө.Золзаяа Утас:70512123 Цахим хаяг: Zolzayau@audit.gov.mn Аккурэйт финанс аудит ХХК-ийн захирал:Ж.Оюунбилэг Утас:70133743 Цахим хаяг:acc.fin.audit@gmail.com
Баруун-Урт сум 2026 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.02.25 № 83

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Баруун-Урт сумын Срон нутгийн хөгжлийн сан, Боловсролын яам, "Цайрт минерал" ХХК, Тэгш хамран сургах төсөл болон сургуулийн 100 жилийн ойн хандиваар нийт 261,881.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандив, тусламжаар бүртгэгдсэн байна. Мөн Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын А/10 дугаар тогтоолоор Боловсрол өргөө ОНӨҮГ-ээс 2,488,180.5 мянган төгрөгийн өртөг бүхий нэгдсэн дотуур байрыг холбогдох хөрөнгийн хамт балансаас балансад шилжүүлэн авч бүртгэсэн байна. Дээрх хөрөнгө оруулалт нь тайлант онд байгууллагын хөрөнгийн хэмжээ, бүтцэд материаллаг нөлөө үзүүлсэн тул энэхүү асуудалд анхаарал хандуулж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд худалдан авах ажиллагаа төлөвлөгөөний дагуу хэрэгжсэн боловч 12 дугаар сард санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс дотуур байрны хүүхдийн хоол, утасгүй интернэтийн сүлжээ, цахим анги байгуулах тохижилттой холбоотойгоор 11 байгууллага, 1 иргэнд нийт 139,571.4 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл үүссэн байна.

D:\Бичиг хэрэг\2026\Явсан бичиг\A4 foot.docx

2226050025

Төсвийн санхүүжилтийн хугацаа, өр төлбөрийн бүртгэл, ангилал, тайлагнал нь аудитын явцад мэргэжлийн шүүлт шаардсан бөгөөд дээрх нөхцөл байдал нь байгууллагын санхүүгийн байдал, төлбөрийн чадварт нөлөөлөх эрсдэлтэй тул энэхүү асуудлыг гол аудитын асуудлаар тодорхойлов.

Бид өр төлбөрийн бүртгэл, ангилал, холбогдох баримт, санхүүжилтийн нөхцөлийг шалгаж, холбогдох аудитын горимыг хэрэгжүүлсэн болно.

Бусад асуудал

“Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих EQUAL төсөл”-ийн хүрээнд цахим танхимыг нээж, сурагчдын суралцах боломжийг тэгш хангах, сургалтын орчинд технологийн дэвшлийг нэвтрүүлэх чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байна.

Үүний нэг хэсэг болгон “Хосолсон сургалтын заах арга зүйн чадавхыг бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төслийн хүрээнд багш нарын заах арга зүйг хөгжүүлэх, хосолсон сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор 5 туршилтын хичээл зохион байгуулагдсан. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2026\Явсан бичиг\A4 тоот.docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	370,296,904.35	362,863,165.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	131,802,748.75	7,807,629.94
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	131,802,748.75	7,807,629.94
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	131,802,748.75	7,807,629.94
35	БАРАА МАТЕРИАЛ	238,494,155.60	355,055,535.36
35100	Түүхий эд материал	-	430,930.00
35130	Эм боох материал	-	430,930.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	90,132,121.78	84,081,820.24
35400	Хангамжийн материал	148,362,033.82	270,542,785.12
35410	Бичиг хэргийн материал	734,500.00	1,046,100.00
35420	Аж ахуйн материал	29,812,022.39	30,067,547.39
35430	Сэлбэг хэрэгсэл	14,149,670.00	14,149,670.00
35450	Барилгын засварын материал	-	120,000.00
35470	Бусад хангамжийн материал	117,815,511.43	239,309,137.73
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,026,857,316.06	3,895,444,666.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,026,857,316.06	3,895,444,666.80
39200	Биет хөрөнгө	1,683,562,316.06	3,494,689,666.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	946,240,313.74	3,107,171,136.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	(101,221,853.52)	(474,831,909.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	260,000.00	260,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(260,000.00)	(260,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	775,414,143.97	996,524,345.24
39206	Хуримтлагдсан элэгдэл	(218,854,065.13)	(477,445,439.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	321,666,660.03	604,683,260.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(94,687,583.60)	(295,265,677.16)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,000,000.00	13,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(10,399,999.68)	(11,699,999.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	10,500,000.00	19,950,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,500,000.00)	(13,905,000.06)
39217	Ном	52,404,700.25	26,508,949.13
393	Биет бус хөрөнгө	343,295,000.00	400,755,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	5,590,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(625,000.00)	(3,015,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	344,350,000.00	400,180,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,930,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,397,154,220.41	4,258,307,832.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	100,201,419.40	139,571,368.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,201,419.40	139,571,368.91
413	Өглөг	100,201,419.40	139,571,368.91
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	80,434,510.00	72,818,423.00
413208	Хоолны өглөг	-	32,043,623.00
413213	Бусад зардлын өглөг	80,434,510.00	40,774,800.00
41360	Бусад өглөг	19,766,909.40	66,752,945.91
41361	Байгууллагад төлөх өглөг	16,982,666.40	66,752,945.91
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,784,243.00	-

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,296,952,801.01	4,118,736,463.19
51	Засгийн газрын хувь оролцоо	2,296,952,801.01	4,118,736,463.19
51101	Төрийн	1,300,668,375.93	1,300,668,375.93
512	Хуримтлагдсан үр дүн	(300,477,984.04)	1,521,305,678.14
51210	Өмнөх үеийн үр дүн	(577,294,693.29)	(300,477,984.04)
51220	Тайлант үеийн үр дүн	276,816,709.25	1,821,783,662.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,296,762,409.12	1,296,762,409.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,397,154,220.41	4,258,307,832.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	5,733,661,529.31	9,934,551,031.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	393,356,529.31	2,618,286,431.98
120	Нийтлэг татварын бус орлого	393,356,529.31	2,618,286,431.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,250,000.00	143,092,381.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,464,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,250,000.00	27,470,000.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	105,158,081.60
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	326,949,750.51	2,308,512,699.88
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	63,156,778.80	166,681,350.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,340,305,000.00	6,875,264,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,853,244,200.00	6,188,296,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,853,244,200.00	6,188,296,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	487,060,800.00	686,968,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,060,800.00	686,968,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,451,677,254.40	7,610,954,122.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,451,677,254.40	7,610,954,122.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,122,097,202.45	7,226,650,765.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,707,907,772.96	4,872,054,855.31
210101	Үндсэн цалин	2,235,739,462.48	2,712,151,333.45
210102	Нэмэгдэл	1,260,508,361.45	1,749,673,052.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	143,214,298.33
210104	Урамшуулал	211,659,949.03	267,016,170.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	462,211,267.15	653,189,425.10
210201	Тэтгэврийн даатгал	313,527,316.15	442,229,201.61
210202	Тэтгэмжийн даатгал	37,442,147.07	52,772,992.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,923,501.83	26,401,559.00
210204	Ажилгүйдлийн даатгал	18,463,560.43	26,357,234.42

210205	Эрүүл мэндийн даатгал	73,854,741.67	105,428,437.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	412,948,997.65	637,167,072.74
210301	Гэрэл, цахилгаан	27,067,386.47	58,364,988.40
210302	Түлш, халаалт	345,475,399.18	497,334,803.31
210303	Цэвэр, бохир ус	40,406,212.00	81,467,281.03
2104	Хангамж, бараа материалын зардал	-	43,801,926.74
210408	Бараа материал акталсаны зардал	-	43,801,926.74
2105	Нормативт зардал	-	258,189,293.00
210502	Хоол, хүнс	-	258,189,293.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,698,880.00	49,800,000.00
210604	Урсгал засвар	66,698,880.00	49,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,193,303.87	105,166,142.91
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,464,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	66,193,303.87	94,701,842.91
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	406,136,980.82	607,282,050.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	168,591,271.81	150,045,048.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,031,950.00	29,228,400.60
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	207,513,759.01	428,008,601.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	329,580,051.95	384,303,356.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	329,468,249.60	384,301,929.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	305,711,949.60	384,301,929.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,756,300.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	111,802.35	1,427.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,802.35	1,427.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	281,984,274.91	1,882,596,909.90
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	5,167,565.66	60,813,247.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,167,565.66	60,813,247.72
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,167,565.66	60,813,247.72
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	5,167,565.66	60,813,247.72
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(4)-(5)	276,816,709.25	1,821,783,662.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,343,555,000.00	7,018,356,981.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	-
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,250,000.00	143,092,381.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,464,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,250,000.00	27,470,000.00
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	105,158,081.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,340,305,000.00	6,875,264,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,853,244,200.00	6,188,296,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,853,244,200.00	6,188,296,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	487,060,800.00	686,968,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	487,060,800.00	686,968,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,152,818,593.96	7,094,145,600.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,152,818,593.96	7,094,145,600.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,827,518,892.01	6,723,484,873.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,704,292,688.95	4,872,054,855.31
210101	Үндсэн цалин	2,232,124,378.47	2,712,151,333.45
210102	Нэмэгдэл	1,260,508,361.45	1,749,673,052.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	143,214,298.33
210104	Урамшуулал	211,659,949.03	267,016,170.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	465,826,351.16	653,189,425.10
210201	Тэтгэврийн даатгал	317,142,400.16	442,229,201.61
210202	Тэтгэмжийн даатгал	37,442,147.07	52,772,992.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,923,501.83	26,401,559.00
210204	Ажилгүйдлийн даатгал	18,463,560.43	26,357,234.42
210205	Эрүүл мэндийн даатгал	73,854,741.67	105,428,437.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	412,948,997.65	637,167,072.74
210301	Гэрэл, цахилгаан	27,067,386.47	58,364,988.40
210302	Түлш, халаалт	345,475,399.18	497,334,803.31
210303	Цэвэр, бохир ус	40,406,212.00	81,467,281.03
2105	Нормативт зардал	-	241,489,900.00
210502	Хоол, хүнс	-	241,489,900.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,950,000.00	49,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	450,000.00	-
210604	Урсгал засвар	60,500,000.00	49,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,615,572.87	102,423,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,464,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	48,615,572.87	91,958,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,885,281.38	167,360,620.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,311,981.38	141,616,720.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,573,300.00	25,743,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	325,187,899.60	370,659,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	325,187,899.60	370,659,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	301,431,599.60	370,659,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,756,300.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	111,802.35	1,427.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,802.35	1,427.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	190,736,406.04	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	200,904,997.00	48,206,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,904,997.00	48,206,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	200,904,997.00	48,206,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	200,904,997.00	48,206,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(200,904,997.00)	(48,206,500.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(10,168,590.96)	(123,995,118.81)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	141,971,339.71	131,802,748.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,802,748.75	7,807,629.94

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(577,294,693.29)	2,020,136,091.76
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(577,294,693.29)	2,020,136,091.76
9	Тайлант үеийн үр дүн	-	-	276,816,709.25	276,816,709.25
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(300,477,984.04)	2,296,952,801.01
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(300,477,984.04)	2,296,952,801.01
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	(300,477,984.04)	2,296,952,801.01
19	Тайлант үеийн үр дүн	-	-	1,821,783,662.18	1,821,783,662.18
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,300,668,375.93	1,296,762,409.12	1,521,305,678.14	4,118,736,463.19

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
1	УРСГАЛ ЗАРДАЛ				
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,351,616,300.00	7,142,352,100.41	209,264,199.59	97.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,972,331,600.00	4,872,054,855.31	100,276,744.69	97.98
210101	Үндсэн цалин	3,198,117,100.00	2,712,151,333.45	485,965,766.55	84.80
210102	Нэмэгдэл	1,590,024,600.00	1,749,673,052.63	159,648,452.63	110.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт		143,214,298.33	143,214,298.33	
210104	Урамшуулал	184,189,900.00	267,016,170.90	-82,826,270.90	144.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	671,541,500.00	653,189,425.10	18,352,074.90	97.27
210201	Тэтгэврийн даатгал	456,648,200.00	442,229,201.61	14,418,998.39	96.84
210202	Тэтгэмжийн даатгал	53,723,300.00	52,772,992.36	950,307.64	98.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	26,861,700.00	26,401,559.00	460,141.00	98.29
210204	Ажилгүйдлийн даатгал	26,861,700.00	26,357,234.42	504,465.58	98.12
210205	Эрүүл мэндийн даатгал	107,446,600.00	105,428,437.71	2,018,162.29	98.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	680,591,900.00	637,167,072.74	43,424,827.26	93.62
210301	Гэрэл, цахилгаан	66,123,400.00	58,364,988.40	7,758,411.60	88.27
210302	Түлш, халаалт	517,202,400.00	497,334,803.31	19,867,596.69	96.16
210303	Цэвэр, бохир ус	97,266,100.00	81,467,281.03	15,798,818.97	83.76
2105	Нормативт зардал	261,489,900.00	241,489,900.00	20,000,000.00	92.35
210502	Хоол, хүнс	261,489,900.00	241,489,900.00	20,000,000.00	92.35

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,800,000.00	49,800,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	49,800,000.00	49,800,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	110,458,100.00	107,913,000.00	2,545,100.00	97.70
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	10,464,300.00	10,464,300.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	99,993,800.00	97,448,700.00	2,545,100.00	97.45
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	214,518,000.00	210,077,120.00	4,440,880.00	97.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	187,799,100.00	183,358,220.00	4,440,880.00	97.64
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	26,718,900.00	26,718,900.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	390,885,300.00	370,659,300.00	20,226,000.00	94.83
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	390,885,300.00	370,659,300.00	20,226,000.00	94.83
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,427.26	(1,427.26)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,427.26	(1,427.26)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,351,616,300.00	7,018,356,981.60	333,259,318.40	
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,351,616,300.00	6,875,264,600.00	476,351,700.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих	7,351,616,300.00	6,875,264,600.00	476,351,700.00	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хүрээнд бий болсон нэмэлт орлого		37,934,300.00		
	Нэр данс зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого		105,158,081.60		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		131,802,748.75		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		7,807,629.94		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	171	171		
620001	Удирдах ажилтан	1	1		100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	126	126		100.0
620003	Үйлчлэх ажилтан	44	44		100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сургууль үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулан хандивласан хөрөнгө оруулалтыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	1	117,055.5	1	117,055.5			1	117,055.5				
2025 оны эхний 9 сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх цалин хөлс нь цалингийн хүснэгтээр тооцоолсон цалин хөлснөөс зөрүүтэй	1	3,942.1			1	3,942.1	1	3,942.1				
Дүн	3	120,997.6	2	117,055.5	1	3942,1	2	120,997.6	1	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны эцэст 11 байгууллага, 1 иргэнд өглөгтэй гарсан	1	-					1	-				
Үдийн цай, дотуур байрны сурагчдын хүнсний материал худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулалт явуулсан боловч tender.gov.mn цахим системд мэдээллийг дутуу оруулсан, сонгон шалгаруулалт явуулсан тухай анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй	1	-	1	-				1	1	-	1	-
Дүн	2	-					2	-				